



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А1635

Улиастай

“Цагаанхайрхан сумын соёл, аялал
жуулчлалын хөгжил-2024” хэлэлцүүлэг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.9 дэх заалт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Цагаанхайрхан сумын соёл, аялал жуулчлалын хөгжил-2024” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр Цагаанхайрхан суманд зохион байгуулсугай.

2.Хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэлэлцүүлэг зохион байгуулахад зарцуулах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Азжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Г.ӨЙРБАЯР



Захирамж -2024

3109010956

Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын
09 -ны өдрийн 125 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**“Цагаанхайрхан сумын соёл, аялал жуулчлалын хөгжил-2024”
сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга:	Д.Пүрэвдорж	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	З.Ариунтуяа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл хариуцсан ажилтан
	Б.Энхзул	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Гадаад харилцааны албаны дарга
	М.Нямдорж	Соёл, урлагийн газрын дарга
	Б.Очирбат	Цагаанхайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга
	С.Бат-Өлзий	Цагаанхайрхан сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга	Я.Зэндмэнэ	Цагаанхайрхан сумын Соёлын төвийн эрхлэгч

Аймгийн Засаг даргын 0024 оны 07 дугаар сарын
09-ны өдрийн 1255 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“Цагаанхайрхан сумын соёл, аялал жуучлалын хөгжил-2024”
сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах зардал**

№	Зардалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Хоол	200 хүн	12000	2400000
2	Цай	200 хүн	6000	120000
3	Зочдын хоол, цай	50	60000	3000000
4	Цэвэр ус	400	800	320000
5	Хүндэтгэлийн гэрийн түрээс	1 өдөр	1800000	1800000
6	Тайз түрээс	1 өдөр		2500000
7	Танхимын түрээс	1 өдөр		1542000
8	Шатахуун			3000000
9	Мандат	200	2000	400000
10	Урилга	50	2000	100000
11	Анонс			440000
12	Дэвтэр	200	4000	800000
13	Бал	200	500	100000
14	Бичгийн цаас	4	19000	78000
15	Принтерийн хор	4	50000	200000
16	Бусад зардал /Асар, ширээ, бүтээлэг, үйл ажиллагааны хэрэглэгдэхүүний түрээсийн төлбөр/			3000000
				19800000